

2023 .03. 07

БАТЛАВ,
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ЗЭНДМАА

2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

**ЧАНАРЫН ГАРЫН АВЛАГА, МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЖУРМЫН
ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл:

Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар байгуулагдаж, Засгийн Газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор Хүнсний аюулгүй байдал үндэсний лавлагаа лабораторийн харьяанд байсан эмийн хяналтын лаборатори нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт шилжин ирсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын чиг үүргийг нэг дор төвлөрүүлэн, хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан лабораторийн чанарын менежментийн тогтолцоо, баримтлах бодлого, зохицуулалтын үйл ажиллагааны дүрэм, журам, бүртгэлийн маягыг шинэчлэх ажлыг хийж эхлүүлээд байна.

Энэхүү журмын төслийг боловсруулснаар ДЭМБ зөвлөмжийн дагуу журамд тусгагдаагүй зохицуулалтын заалтуудыг нарийвчлан оруулж, олон улсын жишигт нийцүүлснээрээ онцлогтой бөгөөд MNS/ISO/IEC 17025:2018 стандартын дагуу чадавхижуулах сургалтыг тогтмол зохион байгуулж, шаардлагатай ном, гарын авлага, зөвлөмжөөр хангаж ажиллах нь үр дүнтэй юм.

Хоёр. Зорилго:

1. ЭЭХХЗГ-ын Эм шинжлэх лабораторийн Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журмын төслийг MNS/ISO/IEC 17025:2018 стандартад нийцүүлэн боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах
2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу "Эмийн лабораторийн зохистой дадал"-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, журамд тусгагдаагүй зохицуулалтын заалтуудыг нарийвчлан оруулж, олон улсын жишигт нийцүүлснээрээ онцлогтой.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл:

1. Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журмын төслийг боловсруулах;
2. Лабораторийн чанарын менежментийн тогтолцоо үйл ажиллагааны талаар баримтлах бодлого, зохицуулалтын үйл ажиллагааны дүрэм, журам, бүртгэлийн маягыг шинэчлэх ажлын талаар холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан санал солилцох хэлэлцүүлэг зохион байгуулах;
3. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг төсөлд тусган, эцэслэх;
4. Журмын төслийн эцсийн хувилбарыг оролцогч талуудад танилцуулах

Солонгос - 92009090.

Дөрөв. Зохион байгуулагч:

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм шинжлэх лаборатори

Тав. Хэрэгжүүлэх арга зам

1.ЭЭХХЗГ-ын даргын 2023 оны А/14 тушаалын дагуу Эм шинжлэх лабораторийн Чанар хариуцсан ахлах мэргэжилтэн, Техник хариуцсан ахлах мэргэжилтэн, химийн лаборатори хариуцсан ахлах мэргэжилтэн, микробиологийн лаборатори хариуцсан ахлах мэргэжилтэн нар нь “Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журам”-ын төслийг MNS/ISO/IEC 17025;2018 стандартын дагуу олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах.

2. MNS/ISO/IEC 17025;2018 стандартын дагуу боловсруулсан “Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журам”-ын төслийг Эм эмнэлгийн хэрэгсэл хяналт зохицуулалтын газрын эмийн бүртгэлийн хэлтэс, эм шинжлэх лабораторийн ажилчид, холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулан саналыг авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.

3. MNS/ISO/IEC 17025;2018 стандартын дагуу Чанарын гарын авлагыг нэгдүгээр хавсралтаар, менежментийн тогтолцооны журмыг хоёрдугаар хавсралтаар боловсруулах сэдвийг үзүүлэв.

Зургаа. Санхүүжүүлэгч байгууллага:

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага , нийт үнэ 8,750,000 (найман сая долоон зуун тавин мянган төгрөг)

Долоо. Хугацаа:

2023 оны 03 дугаар сарын 1-нээс 05 дугаар сарын 31-ны өдөр

Найм. Хүрэх үр дүн:

1. Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журмын төслийг боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
2. Журмын төслийн эцсийн хувилбарыг оролцогч талуудад танилцуулж эцэслэн боловсруулж батлуулах.

ХЯНАСАН:

Хуулийн асуудал хариуцсан
Ахлах мэргэжилтэн



Л.Батзориг

Санхүү, Төсвийн асуудал хариуцсан
ахлах нягтлан бодогч



А.Болор-Эрдэнэ

БОЛОВСРУУЛСАН:

Эм шинжлэх лабораторийн Чанар
хариуцсан ахлах мэргэжилтэн



Ш.Сонинхүү